



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2021.10.18 № 02/2001

танай _____ -ны № _____ -т

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ХОРООНЫ ДАРГА
Ц.ШАРАВЖАМЦ ТАНАА**

Тогтоол хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн даргын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 186 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын комисс тус байгууллагын Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн Гадаад харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, тус хэлтсийн Салбарын гадаад харилцааны зохицуулалт, ёслол, протокол хариуцсан мэргэжилтэн, Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Спортын тэмцээн, наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн, Бодлого төлөвлөлтийн газрын Магадлан итгэмжлэл, стандартын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Паралимпийн спортын шигшээ багийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны сонгон шалгаруулалтыг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.

1. Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн Салбарын гадаад харилцааны зохицуулалт, ёслол, протокол хариуцсан мэргэжилтний албан тушаалд өрсөлдөхөөр хүсэлт ирүүлсэн Эрхэмбаатарын Энхсоёл нь албан тушаалын тодорхойлолтод тавигдсан “Боловсрол, Мэргэжил, Мэргэшил” хэсгийг 100 хувь хангаж байсан тул тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцуулсан бөгөөд сонгон шалгаруулалтад нийт 100 оноо авахаас 55 оноо,

2. Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Спортын тэмцээн, наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалд өрсөлдөхөөр хүсэлт ирүүлсэн Пүрэвзулын Идэрхангай нь албан тушаалын тодорхойлолтод тавигдсан “Боловсрол, Мэргэжил, Мэргэшил” хэсгийг 100 хувь хангаж байсан тул тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцуулсан бөгөөд сонгон шалгаруулалтад нийт 100 оноо авахаас 61.2 оноо,

3. Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Паралимпийн спортын шигшээ багийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд өрсөлдөхөөр хүсэлт ирүүлсэн Басандайн Бямбацэцэг нь албан тушаалын тодорхойлолтод тавигдсан “Боловсрол, Мэргэжил, Мэргэшил” хэсгийг 100 хувь хангаж байсан тул тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцуулсан бөгөөд сонгон шалгаруулалтад нийт 100 оноо авахаас 62.3 оноо тус тус авсан байна.

Э.Энхсоёл, П.Идэрхангай, Б.Бямбацэцэг нарыг тус тусын албан тушаалд “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг хүргүүлж байна.


21004986

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.5 дахь хэсэгт заасан шаардлагыг тус тус хангаж байгаа тухай баримтыг холбогдох байгууллагуудаас нь авч нэр дэвшигчийг томилсон шийдвэрийн хамт тус тус ирүүлнэ үү.

Хавсралт /.. хуудастай.

ГИШҮҮН

Д.БААТАРСАЙХАН





МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 270

Улаанбаатар хот

Г Нэр дэвшүүлж, санал болгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2 дахь заалт, шалгалтын комиссын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэлтсийн Спортын тэмцээн, наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалд Пүрэвзулын Идэрхангайг, Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн Салбарын гадаад харилцааны зохицуулалт, ёслол, протокол хариуцсан мэргэжилтний албан тушаалд Эрхэмбаатарын Энхсоёлыг, Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Паралимпийн спортын шигшээ багийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Басандайн Бямбацэцэгийг тус тус томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч П.Идэрхангайг Спортын тэмцээн, наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалд, Э.Энхсоёлыг Салбарын гадаад харилцааны зохицуулалт, ёслол, протокол хариуцсан мэргэжилтний албан тушаалд, Б.Бямбацэцэгийг Паралимпийн спортын шигшээ багийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд тус тус томилохыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга /Ц.Шаравжамц/-д санал болгосугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ

